

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2009 онд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг”-ийг баталж, үүний дагуу Концессын тухай хуулийг 2010 онд баталснаар Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаарх эрх зүйн орчны суурь тавигдсан. Үүнээс хойш олон улсын жишиг, практик шаардлагад нийцсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор 2022 оны 12 сарын 09-ны өдөр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталсан бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу түншлэлийн төслийн судалгаа, үнэлгээ хийх, эрсдэлийг үнэлэх, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, төслийн хэрэгжилт, тайлагналт, хяналт хэрэгжүүлэх болон төсөл хөгжүүлэх сангийн харилцаануудыг зохицуулсан журмууд болон Түншлэлийн төвийн дүрмийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 404, 405 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд хэрэгжүүлж эхлээд байна.

Хөгжлийн бодлогын богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр цөөнгүй тооны төсөл, хөтөлбөрийг тусгасан. Тухайлбал, Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр нийт 30 төсөл батлагдсан.

Гэвч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш эрчим хүчний салбарын 3, зам, тээврийн салбарын 2, байгаль орчны салбарын 1, чөлөөт бүсийн хөгжлийн 1 гэсэн нийт 7 төслийн санал ирсэн бөгөөд эдгээрээс хуульд заасны дагуу 1 төслийн бүрэн шинжилгээ хийгдсэн, 3 төсөл бүрэн шинжилгээний шатанд, 1 төсөл урьдчилсан үнэлгээний шатанд, 2 төслийн санал холбогдох журамд заасан шаардлагыг хангаагүй байсан тул салбарын яаманд буцаасан байна.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.31-т “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг олон улсын жишигт хүргэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ”, мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж тус тус зааснаас гадна Улсын Их Хурлын 2024 оны 52 дугаар тогтоолоор төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжиж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийг өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Иймд, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслүүдийн процесс ажиллагааг хялбарчлах, түншлэлийн хүрээг тэлж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээнээс гадна хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцсэн төсөл хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, орон нутгийн хүрээнд түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх боломжоор тэгш хангах, түншлэлийн төсөлд тавигдах шаардлагыг багасгаж хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжихээр тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь дараах нэмэлт, өөрчлөлтийг агуулсан болно: Үүнд:

1. Тус хуулийн хүрээнд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт түншлэлийг хэрэгжүүлэхээр байгааг өргөжүүлэн эдгээр салбараас гадна хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтод нийцсэн аливаа төсөл хөтөлбөрийг хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтад тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн түншлэлийн цар хүрээг өргөтгөхөөр хуулийн төсөлд тусгасан. Түүнчлэн хуулийн одоогийн зохицуулалтаар батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа, банк, санхүүгийн зах зээлийн бүх төрлийн үйлчилгээ, үйл ажиллагаа, уул уурхайн салбарын дэд бүтцээр дамжуулан олон нийтэд үйлчилгээ үзүүлэхээс бусад ашиг олох зорилготой ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагааг түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглосон байсныг хүчингүй болгож, аливаа салбарт хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхээр зохицуулсан.

2. Хуульд зааснаар түншлэлийн төслийн саналыг хувийн хэвшлээс салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянасан саналаа түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас төслийн урьдчилсан үнэлгээ хийлгэхээр Түншлэлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлэхээр, Түншлэлийн төв ТӨААТҮГ нь төслийн урьдчилсан үнэлгээг салбарын яамтай хамтран 30 хоногийн дотор хийж үр дүнг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас төслийн урьдчилсан үнэлгээг хянаж, төслийн бүрэн шинжилгээ хийх багийг Түншлэлийн төв дээр тулгуурлан байгуулахаар, төслийн бүрэн шинжилгээ хийх баг нь төслийн бүрэн шинжилгээг 6 сарын дотор /төслийн онцлогоос хамааран нэг удаа 6 хүртэл сараар нэмж сунгах боломжтой/ хийн холбогдох тайлан, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төслийн холбогдох судалгаа тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн хянуулж, зөвшөөрөл авч төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр буюу төслийн судалгаа, үнэлгээг хийхэд хэд хэдэн байгууллага оролцсон, үе шат дамжлага ихтэй, багагүй хугацаа зарцуулахаар байсныг зарим дамжлага үе шатыг цөөлж түншлэлийн төслийн саналыг хувийн хэвшил, салбар яамдаас Түншлэлийн төв ТӨААТҮГ-т шууд хүргүүлэх, түүнчлэн төслийн судалгаа шинжилгээг 1 үе шаттай хийхээр тусгасан.

3. Хуульд түншлэлээр хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний болон дэд бүтцийн бүхий л төслүүдэд урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, холбогдох судалгаануудыг хийж, тэдгээрийн санал дүгнэлтэд үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргахаар байсныг төрийн үйлчилгээний төслүүдэд урьдчилсан болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүйгээр холбогдох судалгааг хийсний үндсэн дээр хэрэгжүүлэх эсэх санал, дүгнэлтийг гаргах боломжтой байхаар, харин дэд бүтцийн төслийн тухайд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан төслийг хэрэгжүүлэх бөгөөд техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах шатанд хийгдэх шинжилгээ болон холбогдох бусад судалгааны давхардлыг арилгаж, зохицуулалтыг тодорхой болгосон.

4. Улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100 000, түүнээс дээш хүн амтай аймаг тодорхой салбарт түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой. Энэ хүрээнд нийслэл болон 9 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал бие даан шийдвэр гаргаж, түншлэлийн төсөл хэрэгжүүлэх боломжтой байсан бол нэмэлт, өөрчлөлтөөр нийслэлээс гадна бүх аймагт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бие даан хэрэгжүүлэх боломжийг нээсэн. Мөн тухайн аймаг болон нийслэл нь хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн төслөөс гарах санхүүгийн болон

бусад үр дагаврыг өөрөө хариуцах буюу улсын төсвөөс ямар нэг баталгаа, санхүүжилт олгохгүй байх талаар холбогдох зүйлийг нэмсэн.

5. Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг урьдчилсан болон уралдаант шалгаруулалт гэсэн 2 үе шаттайгаар зохион байгуулдаг байсныг шат дамжлагыг нэгтгэж, процесс ажиллагааг хялбарчилж, уралдаант шалгаруулалтыг нэг үе шаттайгаар зохион байгуулахаар өөрчилсөн. Ингэснээр хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахад зарцуулах хугацаа багасна.

6. Түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд нийтлэг болон тусгай гэсэн нийт 22 шаардлага тавигддаг байсан бол хэт ерөнхий, тухайн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх эсэхийг тодорхойлоход ач холбогдолгүй шаардлагуудыг хасаж, нийтлэг болон тусгай гэж ангилахгүйгээр тухайн төсөлд тавигдах шаардлага байдлаар хуулийн төсөлд тусгасан.

7. Түүнчлэн Концессын тухай хуулийн хүрээнд гэрээ байгуулсан зарим төслүүдийн хэрэгжилтийн шатанд тулгарсан асуудлуудад үндэслэн түншлэлийн төслийн хэрэгжилтийг дэмжих, талуудын хариуцлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах чиглэлд холбогдох зарим зохицуулалтыг тусгасан болно.

---oOo---